



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА НЯМ-ОСОРЫН УЧРАЛ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn


2026.03.12 № ЗГ-1/08
танай _____-ны № _____-т

Үйл ажиллагааны хөтөлбөрийн
хэрэгжилтийг өргөн мэдүүлэх тухай

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2025 оны гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР

000264000932



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.03.09 № ХЭГ/753
танай _____-ны № _____-т

Тов тогтоолгох тухай

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2025 оны гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт 24 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ


000965003457

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

"19.2."Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2025 оны гүйцэтгэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2025 оны гүйцэтгэлийн тайланг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов" гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2026 оны 03 дугаар сарын 09-ны
өдрийн 108/753 тоот албан бичгийн
хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН
ЯВЦ, ҮР ДҮНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2026 он

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН
ЯВЦ, ҮР ДҮНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2026 оны 01 дүгээр сарын 20

Улаанбаатар хот

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор үндсэн 4 бодлогын хүрээнд 620 зорилт, 1396 арга хэмжээ, төсвийн ерөнхийлөн захирагч болон хөтөлбөрийн үр дүнгийн 219 хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр (цаашид “үйл ажиллагааны хөтөлбөр” гэх)-ийн үндэсний түвшинд гаргах 16 үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин болон тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (цаашид “үйл ажиллагааны төлөвлөгөө” гэх), төлөвлөгөөний хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд гарах үр дүнгийн 76 шалгуур үзүүлэлт (цаашид “ТЕЗ-ийн үр дүн” гэх), зорилтот түвшин болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 1213 зорилт, арга хэмжээний биелэлтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, “Журам батлах тухай” Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, түүний үр дүнгийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин нь хүлээгдэж байгаа үр дүнд чиглэж байгаа эсэхийг тогтоох, биелэлтийг хангах, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

ХОЁР. АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1, 6.2, 6.3, 6.5, 6.7 дахь хэсэгт заасан аргачлалын дагуу Улсын Их Хурлын харьяа байгууллага, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн захиргааны байгууллагуудаас Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем (new.unelgee.gov.mn)-ээр илгээсэн биелэлтийн явцын тайлан, холбогдох нотлох баримтад үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.


ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнг урьдчилан тодорхойлсон бодлогын 16 шалгуур үзүүлэлт, ТЕЗ-ийн 67 үр дүнгийн 76 шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 575 зорилт, 1213 арга

хэмжээний биелэлтийг тухайн жилийн буюу 2025 онд хүрэх түвшин, өссөн дүнгээр буюу 2028 онд хүрэх түвшинтэй тус тус харьцуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тус хөтөлбөрийн хавсралтаар баталсан бодлогын үр дүнгийн биелэлт 55.5 хувь, өссөн дүнгээр 30.7 хувь, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хавсралтаар баталсан ТЕЗ-ийн үр дүнгийн биелэлт 66.7 хувь, өссөн дүнгээр 46.4 хувь, үйл ажиллагааны төлөвлөгөөний 575 зорилтын дундаж 66.4 хувь, өссөн дүнгээр 37.9 хувь, арга хэмжээний биелэлт 61.5 хувь, өссөн дүнгээр 38.8 хувь байна.

График 1. Биелэлтийн явц, үр дүн хувиар



Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

ДӨРӨВ.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БОДЛОГЫН ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРСЭН ТҮВШИН

4.1.Бодлогын үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлогын үр дүнг хэмжих хяналт-шинжилгээ, үнэлгээний 16 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тайлант хугацааны буюу 2025 оны зорилтот түвшинтэй харьцуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд мэдээллийн эх сурвалж гараагүй 3-аас бусад 13 үр дүнгийн үзүүлэлтийн дундаж 55.5 хувь байна. (Хавсралт-1)

Бодлогын 13 үр дүнгийн үзүүлэлтийн 6 буюу 46.2 хувь нь 85-аас дээш хувийн биелэлттэй, 3 буюу 23.0 хувь нь 30-59 хувийн биелэлттэй, 4 буюу 30.8 хувь нь 0-29 хувийн биелэлттэй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр “Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн” (5875.0\$-аас 6585.8\$ хүрсэн), “Зээлжих зэрэглэл” (B3-аас B1 болсон), “Эдийн засгийн эрх чөлөөний байдлын индекс” (76-аас 74-р байр), “Засаглалын үзүүлэлтийн дундаж” (113-аас 111-р байр), “Дэлхийн сайн орон индекс” (106-аас 76-р байр), “Авлигын төсөөллийн индекс” (121-ээс 114-р байр)-ын үзүүлэлтээр төлөвлөсөн зорилтот түвшинд хүрч 100 хувь буюу “үр дүнтэй” гэж дүгнэгдсэн байна. Эдгээр үзүүлэлтээс “Транспэрэнси Интернэшнл” байгууллагаас 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр гаргасан 2024 оны Авлигын төсөөллийн индексээр Монгол Улс 180 орноос 33 оноогоор 114-т эрэмбэлэгдэж, эрэмбийн хувьд байр урагшилсан хэдий ч онооны хувьд өөрчлөлт ороогүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” батлахдаа “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын хүрээнд хүрэх үр дүнг тодорхойлж тусгаагүй байна.

Мэдээллийн эх сурвалж гараагүй 3 шалгуур үзүүлэлтийн талаар дурдвал:

1/ “ядуурлын түвшин” шалгуур үзүүлэлт (2022 оны суурь түвшин 27.1 хувь)-ийн дүнг 2024 онд нийтэд зарласан бөгөөд 2 жил тутам Үндэсний статистикийн хорооноос гаргадаг тул тус үр дүнг хэмжих үзүүлэлтийг 2026 онд гарахаар байна.

2/Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас (МҮХАҮТ) 3 жил тутамд тооцож гаргадаг “Бизнесийн орчны ерөнхий үнэлгээ” судалгааны үр дүнг хамгийн сүүлд 2023 онд нийтэлсэн бөгөөд уг үнэлгээ 2.68 оноо байсан байна. Дараагийн судалгааны дүн 2026 онд гарахаар төлөвлөгдсөн.

Гэвч үйл ажиллагааны хөтөлбөрт энэхүү судалгааны үр дүнг шалгуур үзүүлэлт болгон ашиглахдаа хүрэх түвшинг жил бүр өөр өөр оноогоор, дөрвөн жил дараалан тогтоосон нь судалгааны давтамжтай нийцэхгүй, бодит хэрэгжилтийн боломжийг харгалзаагүй төлөвлөлт болсон байна.

Түүнчлэн 2023 оны суурь түвшинг бодит судалгааны дүн болох 2.68 онооны оронд 2.71 оноогоор тооцон авсан нь мэдээллийн эх сурвалж, тоон өгөгдлийн уялдаа алдагдсан, төлөвлөлтийн алдаа гаргасныг илтгэж байна.

3/ Ёс зүйн хороо, дэд хорооны чадавхын үнэлгээг Төрийн албаны зөвлөлөөс 2026 онд гаргахаар төлөвлөсөн байна.

Төлөвлөсөн зорилтот түвшиндээ хүрээгүй буюу 0-29 хувийн биелэлттэй бодлогын 4 үр дүнгийн шалгуур үзүүлэлт тус бүрийн шалтгаан, нөхцөлийн талаар дэлгэрэнгүй дурдвал,

1.Хүний хөгжлийн индекс (HDI)

- Суурь түвшин: 96/193 (2022)
- Зорилтот түвшин: 95 (2025)
- Хүрсэн түвшин: 104

Шинжилгээ: “НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс гаргадаг “Human Development Report 2025” тайланд Монгол Улсын Хүний хөгжлийн индекс 0.747 байна. Хүний хөгжлийн индекс 2024 онд (2022 оны суурьтай) 0.741 байсан бол 2025 онд (2023 оны суурьтай) 0.747 болж **өссөн** нь хүний хөгжилд чиглэсэн бодлогын нийт үр нөлөө “**эерэг**” гарч, дэлхийн 193 улсаас зэрэглэлээр 104 дүгээрт эрэмбэлэгдэж байгаа бөгөөд зорилтот түвшинд хүрээгүй нь боловсрол, дундаж наслалтаас шалтгаалсан байна.

Жич: Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүний хөгжлийн индексийн мэдээллийн эх сурвалж нь “НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр” гэж заасан хэдий ч мэдээлэл цуглуулах арга зүй нь “Үндэсний хэмжээний түүвэр судалгаа” гэж баталсныг залруулах шаардлагатай. Мөн шалгуур үзүүлэлтийн дагуу хэмжих нэгжийг улс орнуудын зэрэглэлээр бус, (HDI) оноогоор авах нь зүйтэй байна.

Хүснэгт-1. Хүний хөгжлийн 2024 оны үзүүлэлтийг 2025 онтой харьцуулсан байдал

Бодлогын зорилт	Шалгуур үзүүлэлт	2024 он (2022 оны суурь)	2025 он (2023 оны суурь)	Өөрчлөлт өсөлт/бууралт
Хүний хөгжлийг ахиулах	Хүний хөгжлийн индекс (HDI)	0.741	0.747	▲
Өрсөлдөх чадвар	HDI дэлхийн зэрэглэл	96	105	▼
Эрүүл, урт нас	Дундаж наслалт (нас)	72.7	71.7	▼
Чанартай боловсрол	Хүлээгдэж байгаа суралцах жил	14.5	13.6	▼
Боловсролын хуримтлал	Дундаж суралцсан жил	9.4	9.4	—
Амьжиргааны түвшин	GNI per capita (PPP)	10,351	14,787	▲▲

Эх сурвалж: НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Human Development Report 2024, 2025 тайлан”

Дээрх хүснэгтээс эрүүл мэндийн зорилтын хүрээнд авч үзэхэд дундаж наслалт 72.7-оос 71.7 нас болж буурсан нь нас баралтын түвшин, архаг өвчлөл, осол гэмтэл, амьдралын хэв маягтай холбоотой эрсдэлүүд бодлогын түвшинд бүрэн шийдэгдээгүй байгааг харуулж байна. Боловсролын салбарын хувьд, насанд хүрсэн хүний дундаж суралцсан жил хэвээр хадгалагдсан боловч суралцахаар хүлээгдэж байгаа жилийн үзүүлэлт буурсан нь боловсролын хүртээмж, ялангуяа ирээдүйд хүний капиталд сөрөг эрсдэл үүсэх магадлалтайг харуулж байна.

2. Олон улсын өрсөлдөх чадварын үзүүлэлт

- Суурь түвшин: 64 (2023)
- Зорилтот түвшин: 62 (2025)
- Хүрсэн түвшин: 65 (2025 он)

Шинжилгээ: Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварыг 4 үндсэн бүлэг, 20 дэд бүлэг, нийт 336 шалгуур үзүүлэлтээр харьцуулан хэмждэг “Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан-2025”-аас үзэхэд Монгол Улс 65-д эрэмбэлэгдсэн байна. Монгол Улс 2025 онд өмнөх жилээс -5.39 оноогоор оноо буурсан нь эдийн засгийн үзүүлэлтээр 2025 онд 55 дугаарт буюу 13-аар, засаглалын болон бизнесийн байгууллагын үр ашгийн хувьд 3-7-оор, дэд бүтцийн хувьд 2 эрэмбээр тус тус буурсантай холбоотой байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн 20 саяас доош хүн амтай улсад 36-д эрэмбэлэгдэж байна. “Засаглалын үр ашиг” гэсэн дэд бүлгийн үнэлгээ буурсан гол шалтгаан нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн оролцоо өндөр, хөрөнгө оруулагчийн итгэл сул зэргээс шалтгаалсан бол, “Бизнесийн үр ашиг” гэсэн дэд бүлгийн үнэлгээ нь хөрөнгийн зах зээл сул, венчур, инновацын санхүүжилт буюу шинэ технологид суурилсан бизнес өсч, экспортлох боломжгүй, хөдөлмөрийн бүтээмж доогуур зэргээс шалтгаалсан байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн үзүүлэлт болон амьдралын чанар үзүүлэлтээр 68 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

Эх сурвалж: https://imd.widen.net/s/nwvcmpkv6p/yearbook_wcy_2025

3. Дэлхийн инновацын индекс

- Суурь түвшин: 68-р байр (2023)
- Зорилтот түвшин: 67-р байр (2025)
- Хүрсэн түвшин: 78-р байр (2025)

Шинжилгээ: Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагаас (WIPO) улс орнуудын инновацын чадавхыг үнэлж гаргасан 2025 оны Дэлхийн инновацын индексийн тайланд Монгол Улс 139 орноос 78 дугаарт, дундаж орлоготой 36 орноос 22 дугаарт, Зүүн Өмнөд Ази, Зүүн Ази, Номхон далайн бүсийн 17 орноос 13 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

Шинжлэх ухааны нийтлэлүүд, өргөн зурвасын холболт, 5G сүлжээний нэвтрэлт, интернэт холболтын түвшин гэсэн 4-н үзүүлэлт өмнөх оноос сайжирсан үзүүлэлтэй байгаа бол, доорх үзүүлэлтүүдэд ахиц гараагүй муудсан тул Монгол Улс дэлхийн инновацын индексээр 67-р (2024 он) байрнаас ухарч 78 дугаар байрт ороход нөлөөлсөн байна. Тухайлбал,

-патентын тоо буурсан
-судалгаа, хөгжүүлэлтийн (R&D) зардал маш бага
-шинжлэх ухаан, инновацын хөрөнгө оруулалт хангалтгүй зэрэг байдал нөлөөлсөн байна.

Дээрх тайлангаас үзэхэд Монгол Улсын инновацын гарц (69) нь инновацын оролт (87)-оос илүү биелэлттэй байгаа бөгөөд энэ нь, хязгаарлагдмал нөөцөөр харьцангуй сайн

үр дүн гаргаж байгаа ч, суурь орчин ба хөрөнгө оруулалтын чадамж сул хэвээр байна. Инновацын экосистемийг дараагийн шатанд гаргахын тулд институц болон чадавхтай хүний нөөц, хөрөнгө оруулалтыг цогцоор нь сайжруулах шаардлагатай байгааг судалгааны дүгнэлтэд тусгасан байна.

Эх сурвалж: https://imd.widen.net/s/nwvcmpkv6p/yearbook_wcy_2025

4.Хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь

- Суурь түвшин: 76.2% (2023)
- Зорилтот түвшин: 77.0% (2025)
- Хүрсэн түвшин: 72.5% (2025 он)

Шинжилгээ: Үндэсний статистикийн хорооноос 2025 оны мэдээлэл гараагүй байгаа тул “Дотоодын нийт бүтээгдэхүүн, хөдөлмөрийн бүтээмж–2024” тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хувийн хэвшилд бий болсон нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь 2020 онд 77.1, 2022 онд 77.0, харин 2024 онд 72.5 болж буурсан байна. “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулна” гэсэн үр дүнгийн үзүүлэлтийг 2024 оны статистик мэдээлэлд үндэслэн 2025 оны зорилтот түвшинтэй харьцуулан үзэхэд төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй буюу 0-29 хувийн биелэлттэй байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харьцуулбал, хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн хэмжээ нийт ДНБ-д боловсрол, эрүүл мэнд, цахилгаан эрчим хүч, усан хангамж, урлаг, үзвэр тоглоом наадам зэрэг салбарт 40 хүртэл хувийг, тээвэр, уул уурхай, олборлох, мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагааны салбарт 40-80 хүртэл хувийг, бусад салбарт 80-аас дээш хувийг тус тус эзэлж байна.

Эх сурвалж: https://www.nso.mn/uploads/1757041743083-GDP_Productivity_2024.pdf

4.2.Урт хугацааны бодлогын үр дүнтэй уялдсан байдал

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлогын үр дүн “Алсын хараа-2050” урт хугацааны (цаашид “АХ-2050” гэх) бодлогын үр дүнтэй уялдсан эсэхийг харьцуулан үзэхэд 6 үр дүнгийн шалгуур үзүүлэлт (Зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгална, Дэлхийн инновацын үзүүлэлтийг 10 байраар ахиулна, Эдийн засгийн эрх чөлөөний байдлын үзүүлэлтийг 10 байраар ахиулна, Дэлхийн сайн орны үзүүлэлтийг 10 байраар ахиулна, Ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ, Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг олон улсын туршлагад суурилан хэрэгжүүлнэ) урт хугацааны бодлогын үр дүнтэй уялдаагүй байна.

Харин Хүний хөгжлийн бодлогын 1, Амьдралын чанар ба дундаж давхарга бодлогын 2, Эдийн засгийн бодлогын 5, Засаглалын бодлогын 2, нийт 10 үр дүнгийн шалгуур үзүүлэлт уялдсан байна.

Хүснэгт-2.АХ-2050 урт хугацааны бодлогын үр дүнтэй уялдсан шалгуур үзүүлэлтүүд

Алсын хараа-2050 бодлогын үр дүн (дугаар)	Шалгуур үзүүлэлт /хэмжих нэгж	Зорилтот түвшин (2025 он)	ЗГҮАХ бодлого	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин (2025 он)	
2.4	Хүний хөгжлийн бодлого	Хүний хөгжлийн индекс (оноо)	0.85	Хүний хөгжлийн бодлого	Хүний хөгжлийн индекс	байр	95
3.23	Амьдралын чанар ба дундаж давхарга	Өрсөлдөх чадварын үзүүлэлт (оноо)	58		Олон улсын өрсөлдөх чадварын үзүүлэлт	түвшин	62
3.22		Ядуурлын түвшин (хувь)	20%	Эдийн засгийн бодлого	Ядуурлын түвшин	хувь	25
4.34		Нэг хүнд ногдох ДНБ (\$)	6520		Нэг хүнд ногдох ДНБ	ам.доллар	6520
4.32		Эдийн засгийн жилийн дундаж өсөлт (хувь)	6		Эдийн засгийн өсөлт	хувь	8
4.33	Эдийн засгийн бодлого	Инфляц	6		Инфляц	хувь	7
4.43		Бизнесийн орчны ерөнхий үнэлгээ	3.5		Бизнесийн орчны ерөнхий үнэлгээ	оноо	2.8
4.35, 4.36, 4.37		уул, уурхай, боловсруулах үйлдвэр, тээврийн салбарт эзлэх ДНБ-ний эзлэх хувь	-	Хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь	хувь	77	
5.44 - 5.47	Засаглалын бодлого	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтээр хэмжихээр тусгасан	-	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	Засаглалын үзүүлэлтийн дундаж	байр	112
5.49		Авлигын хяналт(хувь)	47.2		Авлигын төсөөллийн индекс	байр	118

Эх сурвалж.УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоол

Дээрх хүснэгтээс харахад АХ-2050 урт хугацааны бодлогын баримт бичигт хүний хөгжлийн индексийг “оноо”-оор хэмжихээр төлөвлөсөн бол үйл ажиллагааны хөтөлбөрт эзлэх “байр”-аар, өрсөлдөх чадварын үзүүлэлтийг АХ-2050-д “оноо”-оор хэмжихээр тусгасан бол үйл ажиллагааны хөтөлбөрт “түвшин”-ээр тооцохоор хэмжих нэгжийг зөрүүтэй байдлаар төлөвлөсөн байна.

Мөн тус 2 бодлогын баримт бичигт тусгагдсан зарим бодлогын үр дүнгийн 2025 онд хүрэх түвшинг ялгаатай төлөвлөсөн байна.Тухайлбал,

Ядуурлын түвшинг АХ-2050 бодлого дээр хүрэх түвшинг 20 хувьд хүргэхээр төлөвлөсөн бол, үйл ажиллагааны хөтөлбөрт 25 хувь гэж, эдийн засгийн дундаж өсөлтийг АХ-2050 бодлогод 6 хувьд хүргэхээр төлөвлөсөн бол, үйл ажиллагааны хөтөлбөрт 8 хувь гэж, инфляцыг АХ-2050 бодлогод 6 хувьд хүргэхээр төлөвлөсөн бол, үйл ажиллагааны хөтөлбөрт 7 хувь гэж, бизнесийн орчны ерөнхий үнэлгээг АХ-2050 бодлогод 3.5 оноонд хүргэхээр төлөвлөсөн бол, үйл ажиллагааны хөтөлбөрт хүрэх түвшинг 2.8 оноонд хүргэхээр тус тус зөрүүтэй тодорхойлсон байна.


ТАВ.ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРСЭН ТҮВШИН

2025 оны жилийн эцсийн байдлаар ТЕЗ-ийн ангилалд хамаарах 67 үр дүнгийн 76

шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрсэн эсэх байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Үүнээс үр дүнг хэмжих, мэдээллийн эх сурвалж гарах хугацаа болоогүй 5, давхардсан 2 шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийгээгүй болно. Хяналт-шинжилгээний дүнгээр ТЕЗ-ийн үр дүнгийн 69 шалгуур үзүүлэлтийг 2025 оны зорилтот түвшинд хүрсэн эсэхэд шинжилгээ хийхэд дундаж нь 65.8 хувь байна.

(Хавсралт 2)

График 2. ТЕЗ-ийн үр дүнгийн биелэлт, тоо болон хувиар



Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Үр дүнгийн 69 үзүүлэлтийг биелэлтийн хувиар нь авч үзвэл “85 хувь буюу түүнээс дээш хувийн биелэлттэй” 37 буюу 53.6 хувь, “60-84 хувийн биелэлттэй” 7 буюу 10.1 хувь, “30-59 хувийн биелэлттэй” 2 буюу 3 хувь, “0-29 хувийн биелэлттэй” 23 буюу 33.3 хувь байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 30-59 хувийн биелэлттэй үнэлэгдсэн 25 шалгуур үзүүлэлтийн шалтгааныг судлан үзэхэд санхүүжилт шийдвэрлэгдээгүй 1, зохион байгуулалттай холбоотой 21, төлөвлөлт болон бусад шалтгаанаар 3 арга хэмжээ байна. Тухайлбал,

1. Нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулна.

Шалгуур үзүүлэлт: Нийслэлийн замын хөдөлгөөний дундаж хурд, км/ц (оргил ачааллын үед)

- Суурь түвшин: 12.0
- Зорилтот түвшин: 16 (2025 он)
- Хүрсэн түвшин: 11 (2025 он)
- Хэрэгжүүлэгч байгууллага: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

Шинжилгээ: Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний урсгалд ажлын өдөр нийт 58 байршилд буюу 28 уулзвар, 4 тойрог уулзвар, 26 замын хэсэгт, ажлын болон амралтын өдрийн өглөөний оргил цагт (07:00-08:00), өдрийн оргил цагт (13:00-14:00), оройн оргил цагт (17:00-18:00) судалгаа хийсэн байна. Судалгааны дүнгээр замын хөдөлгөөн дундаж хурд оройн оргил ачааллын үед ажлын өдрүүдэд 5.57 км/цаг, амралтын өдрүүдэд 8.19 км/цаг, өглөөний оргил цагт ажлын өдрүүдэд 11.07 км/цаг, амралтын өдрүүдэд 16.27 км/цаг гэсэн үр дүн гарсан байна.

Нийслэлд дунд болон урт хугацааны шинжтэй дэд бүтцийн томоохон төслүүдийг (метро, дүүжин зам, BRT зэрэг) хэрэгжүүлэх бэлтгэл ажил, барилга угсралтын ажлууд эрчимтэй үргэлжилж байгаа боловч бодит үр дүн гарч эхлээгүй байна.

2. Цахилгаан эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, хэрэглээний өсөлтийг хангана.

Шалгуур үзүүлэлт: Импортын эрчим хүчний хэмжээ (сая.кВт.ц)

- Суурь түвшин: 2447.6
- Зорилтот түвшин: 2250 (2025 он)
- Хүрсэн түвшин: 2700.7 (2025 он)

Шинжилгээ: Тайлант хугацаанд улсын хэмжээнд 2,700.7 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг импортоор авсан нь 2024 онд авсан дүнгээс 162.8 сая кВт.цагаар буурсан хэдий ч 2025 онд 2250 сая.кВт.цаг хүртэл бууруулах зорилтот түвшинд хүрээгүй байна.

Цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ 12,612.5 сая кВт.цагт хүрч, 2024 оноос 8.4 хувь, 2023 оноос 14.9 хувиар тус тус өсч эрчим хүчний эрэлт хурдацтай нэмэгдэж байгаа тул импортоор авч байгаа эрчим хүчний хэрэглээ буурахгүй байгаа нэг шалтгаан болсон байна.

2025 онд нийт хэрэглээний 78.6 хувийг дотоодын эх үүсвэр, 21.4 хувийг импортын эрчим хүчээр тус тус хангасан, мөн Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 2 дугаар ээлжийн 150 МВт, Тосонцэнгэл ДЦС-ын 18 МВт хүчин чадалтай станц ашиглалтад орж, нийт 168 МВт шинээр нэмэгдсэн боловч ДЦС-3-ын 9 дүгээр турбин генераторын ослоос шалтгаалан 50 МВт хүчин чадал хасагдсанаар бодит нэмэгдэл 118 МВт болсон. Энэхүү нэмэгдсэн хүчин чадал нь хэрэглээний өсөлтийн хурдыг бүрэн нөхөж чадаагүйгээс импортын эрчим хүчний хэмжээ зорилтот түвшинд хүрэх боломжгүйд хүрсэн байна.

ДЦС-3-ын 9 дүгээр турбин генераторт гэмтэл гараагүй бол 172.9 сая квт.ц цахилгаан үйлдвэрлэх боломжтой байсан хэдий ч энэ нь 2025 оны импортын эрчим хүчний хэмжээг бууруулах зорилтот түвшинд хүрэхээргүй байсан.

3.Халдварт бус өвчний шалтгаант нас баралтыг бууруулна.

Шалгуур үзүүлэлт: Нялхсын эндэгдлийн түвшин, 1,000 амьд төрөлтөд (Промиль)

- Суурь түвшин: 12.3
- Зорилтот түвшин: 9 (2025 он)
- Хүрсэн түвшин: 13.7 (2025 он)

Шинжилгээ: Халдварт бус өвчний шалтгаант нас баралтыг бууруулах зорилт үр дүнд хүрээгүй, нялхсын эндэгдлийн түвшин өсч “сөрөг” үр дүн гарсан байна. Эх сурвалжаас үзэхэд нялхсын эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 2024 оны 11 сарын байдлаар 11.9 промиль байсан бол 2025 оны эхний 11 сарын байдлаар 13.7 промиль болж 1.8-аар өссөн байна.

4.Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьд хүргэнэ.

Шалгуур үзүүлэлт: Шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь

- Суурь түвшин: 0.11
- Зорилтот түвшин: 0.12 (2025 он)
- Хүрсэн түвшин: 0 (2025 он)


Шинжилгээ: Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьд хүргэх зорилт үр дүнд хүрээгүй. 2025 оны төсвийн тодотголоор шинжлэх ухааны төсвийг 53,1% хүртэл буцаан татсан нь тус салбарын эрдэм шинжилгээ судалгааны зардал буурахад хүргэсэн байна.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 575 зорилт, 1213 арга хэмжээний биелэлтийн явцад 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 2025 оны жилийн байдлаар 575 зорилтын дундаж 68.6 хувь, өссөн дүнгээр 38.3 хувь, 1213 арга хэмжээний биелэлтийн явц дунджаар 67.9 хувь, өссөн дүнгээр 38.8 хувь байна. (Хавсралт 3)

График 3. Үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний биелэлт, хувиар



Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Үйл ажиллагааны төлөвлөгөөний 575 зорилт, 1213 арга хэмжээний биелэлтийг үнэлгээний ангиллаар харуулбал:

Хүснэгт 3. Зорилт, арга хэмжээний биелэлт, үнэлгээний ангиллаар

Үнэлгээний ангилал	Биелэлт (85 хувиас дээш)	Биелэлт (60-84)	Биелэлт (30-59)	Биелэлт (0-29)	Нийт
Зорилт (тоо)	242	118	117	98	575
Үнэлгээнд эзлэх хувь	42.1	20.5	20.3	17	-
Арга хэмжээ (тоо)	659	147	120	287	1213
Үнэлгээнд эзлэх хувь	54.3	12.1	9.9	23.7	-

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар биелэлтийг дүгнэн үзэхэд арга хэмжээний биелэлтийн дундаж нь Гадаад харилцааны яам 94.5 хувь, Боловсролын яам 82.9 хувь, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 82.6 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт байгууллагаар, хувиар

Д/д	Байгууллага	Зорилт (тоо)	Арга хэмжээний тоо	Тайлант хугацааны биелэлтийн хувь (2025)	2028 онд хүрэх түвшинтэй харьцуулсан хувь
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	22	41	63.4	37.9
2	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	22	45	64.5	32.6
3	Батлан хамгаалахын яам	5	43	77.8	22.8
4	Боловсролын яам	45	86	82.9	39.4
5	Гадаад харилцааны яам	14	44	94.5	57.43
6	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	59	98	72.9	48.6


7	Жендэрийн үндэсний хороо	2	8	75	41.4
8	Зам, тээврийн яам	22	54	56.9	29.6
9	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	23	57	82.6	45.3
10	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар	4	9	82.6	50.1
11	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	27	66	78.7	37.5
12	Сангийн яам	19	41	68.4	53.4
13	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	43	83	53.4	22.1
14	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	39	61	67.2	35.1
15	Хууль зүй, дотоод хэргийн яам	45	87	61.8	45.6
16	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	43	129	65.1	51.7
17	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	19	46	66.6	35.8
18	Шадар сайдын ажлын алба (Онцгой байдлын асуудал эрхэлсэн)	31	60	71.6	27.7
19	Шадар сайдын ажлын алба (Өрсөлдөөний асуудал эрхэлсэн)	5	11	69.8	45.1
20	Эдийн засаг, хөгжлийн яам	26	51	61.1	35.8
21	Эрүүл мэндийн яам	19	45	73.5	34.7
22	Эрчим хүчний яам	46	69	35.1	22.2

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БОДЛОГО ТУС БҮРЭЭР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН

Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг үндсэн 4 бодлогоор нь ангилж үзвэл тухайн жилийн дунджаар Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого хамгийн өндөр буюу 72.5 хувь, Эдийн засгийн бодлого хамгийн бага буюу 61.0 хувийн биелэлттэй байна. (Хавсралт 4)

График 4. Төлөвлөгөөний биелэлт, бодлого, зорилт, хувиар



Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 575 зорилтыг хэрэгжүүлэх 1213 арга хэмжээг хувиар нь авч үзвэл 659 буюу 54.3 хувь нь 85 буюу түүнээс дээш, 147 арга хэмжээ буюу 12.1 хувь нь 60-84, 120 арга хэмжээ буюу 9.9 хувь 30-59, 287 арга хэмжээ буюу 23.7 хувь нь 0-29 хувийн биелэлттэй гэж үнэлэгдсэн байна.

Зорилт, арга хэмжээний биелэлтийг бодлогоор ангилан харуулбал:

Хүснэгт 5.Бодлогын биелэлтийг үнэлгээний ангиллаар харуулбал (хувиар)

Бодлогын нэр	Зорилт (тоо)	Үр дүнгийн ангилал				Биелэлтийн хувь	
		Биелэлт (85 хувиас дээш)	Биелэлт (60-84)	Биелэлт (30-59)	Биелэлт (0-29)	Тухайн жил	Өссөн дүн
Бүсчилсэн хөгжлийн бодлого	84	72	16	15	44	62.1	30.14
Хүний хөгжлийн бодлого	145	166	43	20	51	70.6	39.0
Эдийн засгийн бодлого	205	215	55	64	140	61.0	38.3
Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	141	206	33	21	52	72.5	40.8
Нийт дүн	575	659	147	120	287	66.39	37.91
Нийт дүнд эзлэх хувь		54.3	12.1	9.9	23.7	-	-

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

I.БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БИЕЛЭЛТ

Бүсчилсэн хөгжлийн бодлогын үндсэн 4 зорилтын хүрээнд 84 дэд зорилт, 147 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд зорилт, арга хэмжээний биелэлтийн дундаж 62.1 хувь байна. Эдгээр 147 арга хэмжээний биелэлтийг үнэлгээний ангиллаар авч үзвэл, 85-аас дээш хувийн биелэлттэй 72, 60-84 хувийн биелэлттэй 16, 30-59 хувийн биелэлттэй 15, 0-29 хувийн биелэлттэй 44 арга хэмжээ байна.

Хүснэгт 6.Бүсчилсэн хөгжлийн бодлогын 4 үндсэн зорилтын биелэлтийн дундаж, хувиар

№	Бүсчилсэн хөгжлийн бодлого	Зорилтын тоо	Төсөл, арга хэмжээний тоо	Биелэлтийн дундаж хувь
1	Улаанбаатар хот-"20 минутын хот" стандарт	33	66	71.3
2	Бие даасан эдийн засаг бүхий Улсын зэрэглэлтэй хот, дагуул хот	11	23	64.7
3	Бүсийн төрөлжсөн хөгжил	26	37	45.1
4	Орон нутгийн хөгжил	14	21	60.4

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Тус бодлогын хүрээнд төлөвлөсөн “Улаанбаатар хот-20 минутын хот стандарт” зорилтын биелэлтийн дундаж 71.3 хувь, “Бие даасан эдийн засаг бүхий Улсын зэрэглэлтэй хот, дагуул хот” зорилтын дундаж 64.7 хувь, “Бүсийн төрөлжсөн хөгжил” зорилтын дундаж 45.1 хувь, “Орон нутгийн хөгжил” зорилтын дундаж 60.4 хувь байна.

“Улаанбаатар хот-20 минутын хот стандарт” зорилтын хүрээнд төлөвлөсөн 66 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 37, 60-84 хувийн биелэлттэй 9 арга хэмжээ байна. Тухайлбал:

Бөөрөлжүүтийн 300 МВт-ын цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулах арга хэмжээний хүрээнд 300 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцын ТЭЗҮ-г баталгаажуулж, 150 МВт-ын эхний ээлжийг 2024 оны 12 дугаар сард, 2 дугаар ээлжийн 150 МВт-ын блокыг 2025 оны 10 дугаар сард тус тус сүлжээнд залгасан. Ашиглалтад орсноос хойш нийт 1 тэрбум 27 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн байна.

Харин 30-59 хувийн биелэлттэй 7, 0-29 хувийн биелэлттэй 13 арга хэмжээ байна. Тухайлбал:

-Бохир усны Туул-1 коллекторыг дуусгаж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хүрээнд шугамын ажлын зургийн дагуу шугам угсралтын ажил явагдаж, 2025 онд нийт 1.3 км шугам угсарсан байна. Энэ онд нийт 6.7 км угсралтын ажил хийгдэнэ гэж төлөвлөснөөс 1.3 км угсралтын ажил хийгдэж, тухайн жилийн биелэлт 19.4 хувьтай байна.

-Орон нутгийн зэрэглэлтэй 14 хот (Хан-Уул, Яармаг, Буянт-Ухаа, Сонгинохайрхан, Толгойт, Баянхошуу, Өнөр, Баянгол, Чингэлтэй, Сэлбэ, Сүхбаатар, Дарь-Эх, Баянзүрх, Амгалан)-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах арга хэмжээ төсөв батлагдаагүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.

“Бие даасан эдийн засаг бүхий Улсын зэрэглэлтэй хот, дагуул хот” зорилтын хүрээнд төлөвлөсөн 23 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 12, 60-84 хувийн биелэлттэй 2, 30-59 хувийн биелэлттэй 3, 0-29 хувийн биелэлттэй 6 арга хэмжээ байна. Тухайлбал:

-Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ барих төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад 2025 онд 21,979.8 сая төгрөгийн санхүүжилт тусгагдаж, тус яамнаас “Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн 21.083 км урт ариутгах татуургын шугам сүлжээ” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2025 оны 01 дүгээр сард зарлан 8 компани оролцсон боловч оролцогчдын маргаан гарч, эцэслэн шийдвэрлэгдээгүйн улмаас 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Төрийн хэмнэлтийн хуулиар төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцсон байна.

“Бүсийн төрөлжсөн хөгжил” зорилтын хүрээнд төлөвлөсөн 37 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 12, 60-84 хувийн биелэлттэй 4 арга хэмжээ, 30-59 хувийн биелэлттэй 2, 0-29 хувийн биелэлттэй 19 арга хэмжээ байна. Тухайлбал:

-Орхон голын сав, Хангайн нурууны экосистемд түшиглэсэн рашаан сувилал, түүх соёлын, археологийн нөөцөд тулгуурласан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй байна.

-Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төслийн гүйцэтгэгч “Пауэр Чайна–Пауэр Чайна Ченгду” түншлэл 2023–2024 онд өөрийн хөрөнгөөр барилга угсралтын ажлын бэлтгэл хангаж, 2025 оны 4 дүгээр сард төслийн ерөнхий зургийг боловсруулж, ажлын зургуудад магадлал хийлгэсэн байна. Барилга угсралтын ажлын эхний үе шатны гүйцэтгэлийг хүлээн авч, урьдчилгаа төлбөрт санхүүжилтийн 30 хувийг олгосон бөгөөд ажлын гүйцэтгэл 18 хувьтай байна.

-Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалттай холбоотой шүүхийн маргаан гарсан тул төсөл удааширсан байна.

-Алтанширээт үйлдвэрлэл, технологийн паркт цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх (20.0 МВт.цаг/тн) төсөл, арга хэмжээний хүрээнд баригдах цахилгаан станц барих ажлын суурь ажлууд болох 110/10 кВт-ын 9.4 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 6.3МВт-ын цахилгааны дэд станц, нүүрс ачиж, буулгах талбайг ашиглалтад оруулсан байна. Тус арга хэмжээг 2025 онд бүрэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 30 хувийн биелэлттэй байна.

“Орон нутгийн хөгжил” зорилтын хүрээнд төлөвлөсөн 21 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 11, 60-84 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ байна. Тухайлбал:

-Холбогдох татварын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг

боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээний хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагалдуулан татварын багц хуулиудад (татварын ерөнхий, хотын албан татвар, ус бохирдуулсны, үл хөдлөх эд хөрөнгийн, байгалийн нөөц ашигласны, агаарын бохирдлын, гаалийн тариф, гаалийн татвар) нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хурлаар, Бүсчилсэн хөгжлийн зорилтод нийцсэн томоохон төсөл, үйл ажиллагаанд татварын дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг хуульчилж, орлого олж эхэлсэн эхний 5 жилд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь байхаар ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаар тус тус батлуулсан бөгөөд Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бие даан тогтоодог татваруудыг бүсийн онцлогт нийцүүлэн ялгаатай тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Харин 30-59 хувийн биелэлттэй 3, 0-29 хувийн биелэлттэй 6 хэмжээ байна. Тухайлбал:

-Орон нутагт шуудангийн илгээмжийн логистикийн дэд төв байгуулах Замын-Үүд боомтод шуудан, логистикийн төв байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгавар батлуулж, 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 02/869 дугаартай албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасны дагуу төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцсон байна.

-Хот, суурин газруудын хүн амын ундны цэвэр усны шугамыг зэс шугамаар солих судалгаа хийж, загвар төсөл хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд нийслэл болон Орхон аймагт хийгдсэн инженерийн шугам сүлжээний шинэчлэл, судалгаа хийгдсэн боловч Сэлбэ дэд төвийн ундны усны шугамыг зэс хоолойгоор солих ажилд санхүүжилт шийдэгдээгүй байна. Мөн Орхон аймагт эдэлгээний хугацаа дууссан инженерийн шугам сүлжээний хэмжээ өндөр (цэвэр ус – 64%, ариутгах татуургын – 62%, дулаан хангамжийн – 40.9%) тул яаралтай шинэчлэх шаардлагатай бөгөөд нийт 215 тэрбум төгрөгийн хөрөнгө шаардлагатай тооцоог гаргасан байна. Сүүлийн жилүүдэд HDPE болон цайрдсан ган хоолойгоор 15 хувийн шинэчлэл хийгдсэн ч зэс хоолой нэвтрүүлэх судалгаагаар өртөг өндөр байгаа нь хэрэглээнд нэвтрүүлэхэд хүндрэлтэй байна.

II. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БИЕЛЭЛТ

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд үндсэн 4 зорилтын хүрээнд 145 дэд зорилт, 282 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд зорилтын дундаж 70.6 хувь, арга хэмжээний биелэлтийн дундаж 73.6 хувь байна. Эдгээр 282 арга хэмжээний биелэлтийг хувиар нь авч үзвэл, 85-аас дээш хувийн биелэлттэй 166, 60-84 хувийн биелэлттэй 43, 30-59 хувийн биелэлттэй 20, 0-29 хувийн биелэлттэй 51 арга хэмжээ байна.

Хүснэгт 7. Хүний хөгжлийн бодлогын 4 үндсэн зорилтын биелэлтийн дундаж, хувиар

№	Хүний хөгжлийн бодлого	Зорилтын тоо	Төсөл, арга хэмжээний тоо	Биелэлтийн дундаж хувь хувь
1	Чинээлэг Монгол хүн	68	124	69.1
2	Эрдэм боловсролтой Монгол хүн	40	84	82.1
3	Эрүүл Монгол хүн	17	43	73.5
4	Баялагтаа эзэн Монгол хүн	20	31	69.1

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Тус бодлогын хүрээнд төлөвлөсөн “Чинээлэг Монгол хүн” зорилтын дундаж 63.1, “Эрдэм боловсролтой монгол хүн” зорилтын дундаж 78.2 хувь, “Эрүүл Монгол хүн”

зорилтын дундаж 72.9, “Баялагтаа эзэн монгол хүн” зорилтын дундаж 69.1 хувь байна.

“Чинээлэг Монгол хүн” зорилтын хүрээнд төлөвлөсөн 124 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 61, 60-84 хувийн биелэлттэй 25, 30-59 хувийн биелэлттэй 12, 0-29 хувийн биелэлттэй 24 арга хэмжээ байна. Тухайлбал:

-Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч бүрийг мөнгөн хуримтлалтай болгож, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд Тэтгэврийн хагас хуримтлалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлж, 1979 оноос хойш төрсөн 807.2 мянган даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг үе шаттай 4 хувиар хуримтлуулах, ингэснээр 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн хувьд суурь тэтгэвэр, тэтгэврийн даатгалын сангаас болон хуримтлалын тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд тус тус тусган боловсруулсан байна. Хуулийн төслүүдийг Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн ч Монгол Улсын Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан дахин хэлэлцүүлэхээр хойшлуулсан байна.

-Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах сорилын төвийг аймаг, дүүрэг бүрд байгуулж, дата өгөгдөлд дүн шинжилгээ хийх спортын шинжлэх ухааны байгууллагын хүчин чадлыг сайжруулах чиглэлээр 2025 онд тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

-Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандалт судалгааг боловсруулсан байна. Мөн дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан боловч холбогдох байгууллагуудаас саналыг нь авч тайлант хугацааны хүрэх үр дүн буюу Улсын Их Хуралд өргөн мэдүүлээгүй байна.

“Эрдэм боловсролтой Монгол хүн” үндсэн зорилтын хүрээнд төлөвлөсөн 84 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 62, 60-84 хувийн биелэлттэй 7 арга хэмжээ байна. Тухайлбал:

-“Өдөр бүр нэг аяга сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлэх /7 хоногийн 5 өдрийг улсын төсвөөр санхүүжүүлэхээр тооцсон/ арга хэмжээний хүрээнд улсын хэмжээнд төрийн өмчийн нийт суралцагчийн 11.8 хувийг 7 хоногийн 1-5 дахь өдөр сүүгээр хангах хөтөлбөрт хамруулсан байна. Төрийн өмчийн ЕБС-ийн 6 дугаар ангид 69859 суралцагч байгаа бөгөөд үүний 21.3 хувийг хамруулсан байна.

Харин 30-59 хувийн биелэлттэй 5, 0-29 хувийн биелэлттэй 10 арга хэмжээ байна. Тухайлбал:

-Кирилл болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэлт хийх, алдаа хянах программ хөгжүүлж, үндэсний хэмжээнд нэвтрүүлэх талаар тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна.

-Хүүхэд, залуучуудыг сургалтын байгууллагын орчинд цахим эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр стандарт боловсруулж мөрдүүлэх чиглэлээр тодорхой ажил хэрэгжүүлээгүй.

-Ерөнхий боловсролын сургуулийн байгалийн ухаан, мэдээллийн технологи, биеийн тамир, эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг шинэчилж хэрэгжүүлэх чиглэлээр бага ангийн (1-5 дугаар анги) сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан боловч хэрэгжүүлж эхлээгүй байна.

“Эрүүл Монгол хүн” үндсэн зорилтын хүрээнд төлөвлөсөн 43 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 26, 60-84 хувийн биелэлттэй 5, 30-59 хувийн биелэлттэй 2, 0-29 хувийн биелэлттэй 10 арга хэмжээ байна. Тухайлбал:

-Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх дэд төв, нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулах арга хэмжээний хүрээнд 2025 онд 2 дэд төв, 8 нийгмийн эрүүл мэндийн төв байгуулахаар төлөвлөсөн боловч санхүүгийн эх үүсвэр батлагдаагүй тул хэрэгжээгүй байна.

-Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээний хүрээнд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажил удаашралтай, төлөвлөсөн хугацаандаа хийгээгүй байна.

“Баялагтаа эзэн Монгол хүн” үндсэн зорилтын хүрээнд төлөвлөсөн 31 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 17, 60-84 хувийн биелэлттэй 6 арга хэмжээ байна. Тухайлбал:

-Ногоон нуур 1008 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд “БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн “Ногоон нуур” 1008 айлын орон сууцны цогцолборын барилга угсралтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулсан.

Харин 30-59 хувийн биелэлттэй 1, 0-29 хувийн биелэлттэй 7 арга хэмжээ байна. Тухайлбал:

-“Миний амины орон сууц” хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх талаар зохицуулсан журам батлагдаагүй тул хэрэгжээгүй байна.

Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн өөрчлөлттэй уялдуулан журмын төслийг дахин боловсруулах шатанд байна.

-“Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих, худалдан авахад ипотекийн зээл олгох журмыг шинэчлэх” арга хэмжээний хүрээнд журмыг шинэчлэн батлаагүй байна. Монголбанк, Ногоон барилгын хүрээлэн хамтран 2026 оноос ипотекийн санхүүжилтийн тодорхой хувийг амины орон сууцанд хуваарилах, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр тохиролцооны шатанд байгаа тухай тайлагнасан байна.

III. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН БИЕЛЭЛТ

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд үндсэн 4, дэд 208 зорилт, 484 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд зорилтын дундаж 61.01 хувь, арга хэмжээний биелэлтийн дундаж 60.4 хувь байна. Эдгээр 484 арга хэмжээний биелэлтийг хувиар нь авч үзвэл, 85-аас дээш хувийн биелэлттэй 215, 60-84 хувийн биелэлттэй 55, 30-59 хувийн биелэлттэй 64, 0-29 хувийн биелэлттэй 140 арга хэмжээ байна.

Хүснэгт 8. Эдийн засгийн бодлогын үндсэн 4 зорилтын биелэлт, хувиар

№	Эдийн засгийн бодлого	Зорилтын тоо	Төсөл, арга хэмжээний тоо	Биелэлтийн дундаж хувь
1	Эдийн засгийн эрх чөлөө	16	28	77.5
2	Бизнес, хөрөнгө оруулалтын орчин	22	49	64.9
3	Эдийн засгийн төрөлжилт, либералчлал	140	342	57.8
4	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт	27	65	62.9

Эх сурвалж. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар

“Эдийн засгийн эрх чөлөө” зорилтын хүрээнд төлөвлөсөн 28 арга хэмжээнээс биелэлт нь 85-аас дээш хувийн биелэлттэй 18, 60-84 хувийн биелэлттэй 3, 30-59 хувийн биелэлттэй 3, 0-29 хувийн биелэлттэй 4 арга хэмжээ байна. Тухайлбал:

-“Инфляцыг 5 хувиас бага түвшинд хадгалах бодлогыг баримтлах” гэсэн арга хэмжээ зорилтот түвшинд хүрээгүй байна. 2025 оны 12 дугаар сарын инфляцын түвшин Монгол Улсын хэмжээнд 7.5 хувь байна. Энэ нь 2024 оны мөн үетэй харьцуулахад 0.8 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

-Гадаадын банкнуудад тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг хялбаршуулсан, ил тод болгож, мэргэшсэн байгууллагууд зах зээлд чирэгдэлгүй нэвтрэх боломжийг бүрдүүлэх төсөл, арга хэмжээний чиглэлээр хийх ажлыг 2025 онд 40 хувьд хүргэхээр төлөвлөсөн удаашралтай байна.

“Бизнес, хөрөнгө оруулалтын орчин” зорилтын хүрээнд төлөвлөсөн 49 арга хэмжээнээс биелэлт нь 85-аас дээш хувийн биелэлттэй 22, 60-84 хувийн биелэлттэй 8 арга хэмжээ байна. Тухайлбал:

-Эдийн засгийг либералчлах, дотоодын хөрөнгө оруулалт болон бизнесийн орчныг сайжруулах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээний хүрээнд Эдийн засгийг либералчлах, дотоодын хөрөнгө оруулалт болон бизнесийн орчныг сайжруулах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл болон энэ хуулийн төслийг дагуулан Хөрөнгө оруулалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар Засгийн газрын хуралдаанд 2 удаа, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, намын бүлгүүдэд тус тус танилцуулсан. Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, хуулийн төслийг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан байна.

Харин 30-59 хувийн биелэлттэй 7, 0-29 хувийн биелэлттэй 12 арга хэмжээ байна. Тухайлбал:

“Монгол, Хятадын “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг (Монгол тал) боловсруулж, батлуулах; “Цагааннуур” чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, техник, эдийн засгийн үндэслэл, судалгаа, нарийвчилсан зураг төслийг боловсруулах, “Алтанбулаг” чөлөөт бүсийн дулааны станцын техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэх, “Алтанбулаг” чөлөөт бүсийн дулааны станцын зураг төсвийг боловсруулах” гэсэн эдгээр 4 арга хэмжээний биелэлт санхүүжилт шийдэгдээгүй шалтгаанаар хэрэгжээгүй байна. (Алтанбулаг чөлөөт бүсийн дулааны станцын ТЭЗҮ, зураг төсөл нь 2012 онд боловсруулагдсан боловч шинэчлэгдээгүй байна.

“Эдийн засгийн төрөлжилт, либералчлал” зорилтын хүрээнд төлөвлөсөн 333 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 144, 60-84 хувийн биелэлттэй 37 арга хэмжээ, 30-59 хувийн биелэлттэй 43, 0-29 хувийн биелэлттэй 109 арга хэмжээ байна. Тухайлбал:

-“Чойр-Мандалговь чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 178 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг хийлгэх” Чойр-Мандалговь чиглэлийн ЦДАШ, 220/110/35 кВ-ын “Чойр”, “Мандал” дэд станцуудын өргөтгөлийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах даалгавар 2024 оны 11 дүгээр сарын 13-ны

өдөр батлагдсан байна. “Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн” УТУГ 2024 оны 12 дугаар сард худалдан авах ажиллагаа зарласан ч амжилтгүй болж, 2025 онд дахин зарлахаар төлөвлөгөөнд оруулсан боловч төсвийн санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцогдож хасагдсан байна.

–“Гангийн үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ, технологийн түвшний үнэлгээ, дэд бүтцийн зураг төсөл боловсруулах” арга хэмжээний хувьд гангийн үйлдвэрийн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулсан хэдий ч, төслийн хүчин чадлыг хөрөнгө оруулагчтай хамтран тогтоох шаардлагаар худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг түр хугацаанд хойшлуулсан байна. “Эрдэнэс ҮТП” ХХК нь Гангийн цогцолборын урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулж байгаа ба одоогоор 70 хувийн биелэлттэй байна.

“Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт” зорилтын хүрээнд төлөвлөсөн 65 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 31, 60-84 хувийн биелэлттэй 7, 30-59 хувийн биелэлттэй 11, 0-29 хувийн биелэлттэй 15 арга хэмжээ байна. Тухайлбал:

–Монгол оронд тархсан харь зүйл ургамлын тархац, түрэмгийллийн өнөөгийн төлөв байдлын судалгааг хийж, хамгааллын цогц арга хэмжээ хэрэгжүүлэх хүрээнд Дорноговийн цөлөрхөг хээр, Говь-Алтайн уулын цөлөрхөг хээр, Алтайн өвөр говийн ургамал газарзүйн тойргийн ургамалжлын судалгаа хийх, 150 зүйл ургамлын тархац нөөцийг тогтоох судалгааны ажлын зардлыг Мазаалай хөтөлбөрийн зардалд тусгасан боловч, төсөв хасагдаж ажил хийгдээгүй байна.

IV. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН БИЕЛЭЛТ

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд үндсэн 4 зорилт, дэд 143 зорилтын дундаж 72.5 хувь, 321 арга хэмжээний биелэлтийн дундаж тухайн жилд 76.8 хувь, өссөн дүнгээр 43.7 хувь байна. Эдгээр 321 арга хэмжээг биелэлтийн хувиар нь авч үзвэл, 85-аас дээш хувийн биелэлттэй 206, 60-84 хувийн биелэлттэй 33, 30-59 хувийн биелэлттэй 21, 0-29 хувийн биелэлттэй 52 арга хэмжээ байна.

Хүснэгт 9. Эдийн засгийн бодлогын үндсэн 4 зорилтын биелэлт, хувиар

№	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	Зорилтын тоо	Төсөл, арга хэмжээний тоо	Биелэлтийн дундаж хувь хувь
1	Хүний эрх, эрх чөлөө	29	51	66.8
2	Авлигагүй засаглал	31	72	80.2
3	Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл	19	37	72.7
4	Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм	62	161	79.3

Эх сурвалж. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

“Хүний эрх, эрх чөлөө” зорилтын хүрээнд төлөвлөсөн 51 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 29, 60-84 хувийн биелэлттэй 4, 30-59 хувийн биелэлттэй 3, 0-29 хувийн биелэлттэй 14 арга хэмжээ байна.

Тухайлбал: “Хууль зүйн туслалцааны төвийн албаны байртай болох” гэсэн арга хэмжээ газрын асуудал шийдэгдээгүйн улмаас хэрэгжээгүй байна.

“Авлигагүй засаглал” зорилтын хүрээнд төлөвлөсөн 72 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 46, 60-84 хувийн биелэлттэй 6 арга хэмжээ байна. Тухайлбал:

-Улсын хэмжээнд камерын хяналтын тогтолцоог хөгжүүлж, мэдээллийг цаг алдалгүй авч шинжилгээ хийх төвийг байгуулах арга хэмжээний хүрээнд “Теле камерын хяналтын дэд төв”-ийг 2024 онд Нийслэлийн 8 дүүрэг, 9 аймагт, 2025 онд 1 дүүрэг, 12 аймагт нэмэгдүүлж, нийт 30 суурьшлын бүсэд камерын хяналтын нэгдсэн системийг үйл ажиллагаанд бүрэн оруулсан бөгөөд “Нэгдсэн удирдлагын төв”-ийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 19177 камер, аж ахуйн нэгж, байгууллагын дэмжлэгээр 75123 камер, авто замын уулзвар, гарцуудад 2,606 камер суурилуулж, нийт 96906 камерыг ашиглалтад оруулсан байна.

Харин 30-59 хувийн биелэлттэй 8, 0-29 хувийн биелэлттэй 8 арга хэмжээ байна. Тухайлбал:

-Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлж төрийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлэх арга хэмжээний хүрээнд БНСУ-ын КОЙКА байгууллагын “Монгол Улсын Төрийн албаны гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах төсөл”-ийн хүрээнд нэгдсэн мэдээллийн системийн туршилтын хувилбарыг хөгжүүлж дуусгасан байна. Төрийн 4276 байгууллагын 40 хувь буюу 1710 байгууллагад тус системийг нэвтрүүлэхээс 14 байгууллагад нэвтрүүлж эхэлсэн байна.

“Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл” зорилтын хүрээнд төлөвлөсөн 37 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 22, 60-84 хувийн биелэлттэй 3, 30-59 хувийн биелэлттэй 3, 0-29 хувийн биелэлттэй 7 арга хэмжээ байна. Тухайлбал:

-“Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” арга хэмжээний хүрээнд хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах” ажлын даалгаврын төсөл батлуулснаас өөр тодорхой ажил хийгдээгүй байна.

-Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэл, газрын хэвлийн баялаг болон газар дээрх баялгийн бүртгэлийг “блокчейн” технологийг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлж, үйлчилгээнд нэвтрүүлэх арга хэмжээний хүрээнд “Блокчейн технологи ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг баталгаажуулах ажлыг зохион байгуулах” үйлчилгээний худалдан авах ажиллагааг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр нээсэн боловч, Төрийн хэмнэлтийн тухай хуулиар санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцсон байна.

“Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм” зорилтын хүрээнд төлөвлөсөн 161 арга хэмжээнээс 85-аас дээш хувийн биелэлттэй 109, 60-84 хувийн биелэлттэй 20 арга хэмжээ байна. Тухайлбал:

-Холбоо, зарлан мэдээллийн тогтолцоонд тоон радио холбооны системийг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тусгай зориулалтын хувцас хэрэглэл худалдан авах 23.9 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас “Starlink” сүлжээ үүсгэгч 37, хайгуулын нисгэгчгүй нисэх төхөөрөмж 32, сургалтын нисгэгчгүй нисэх төхөөрөмж 60, радио холбооны 939 төхөөрөмжийг худалдан авч, орон нутгийн анги, салбаруудад хуваарилан ашиглалтад оруулсан.

Харин 30-59 хувийн биелэлттэй 7, 0-29 хувийн биелэлттэй 23 арга хэмжээ байна. Тухайлбал,

-Үндэсний соёлын нэгдмэл байдлын судалгааг хийх арга хэмжээний хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Үндэсний соёлын нэгдмэл байдлын судалгааг сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөсөн боловч Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар тухайн байгууллагын 2025 оны төсвийн урсгал зардлыг бууруулсантай холбоотойгоор судалгаа хийх төсөв хасагдсан байна.

-Террорист үйлдлийг таслан зогсоох, сөрөг тусгай ажиллагаанд оролцох чиг үүрэг бүхий ангийн бэлтгэл сургуулилт явуулах барилга байгууламж, талбайг шинээр байгуулж, тохижуулах арга хэмжээний хүрээнд тусгай тактикийн болон албаны сургалтын бэлтгэлийн бааз байгуулах Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн “Сургалт, соёл спортын цогцолбор”-ын барилгын зураг, төсвийн зардал Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад тусгагдаж батлагдсан байна. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, шалгарсан хуулийн этгээдэд 699.0 сая төгрөгөөр “Зураг, төсвийн ажил гүйцэтгэх гэрээ” байгуулах мэдэгдлийг хүргүүлсэн боловч, гэрээ байгуулах хуулийн хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцсон байна.

НАЙМ.ДҮГНЭЛТ

8.1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:

- Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 2025 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хавсралтаар батлагдсан бодлогын 13 үр дүнгийн дундаж 55.5 хувь, өссөн дүнгээр 30.7 хувь, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 575 зорилтын тухайн жилийн дундаж 68.6, өссөн дүнгээр 38.3 хувь, арга хэмжээний биелэлт тухайн жилд 67.9 хувь, өссөн дүнгээр 38.8 хувь, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн үзүүлэлтийн дундаж 63.1 хувь, өссөн дүнгээр 46.4 хувь байна.

- Үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлогын үр дүнгийн 16 үзүүлэлтээс 85-аас дээш хувийн биелэлттэй 6, 30-59 хувийн биелэлттэй 3, 0-29 хувийн биелэлттэй 4, мэдээллийн эх сурвалж гарах хугацаа болоогүй 3 үзүүлэлт байна.

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 67 үр дүнгийн 76 шалгуур үзүүлэлтээс үр дүнг хэмжих, мэдээллийн эх сурвалж гарах хугацаа болоогүй 5, үзүүлэлт давхардсан 2 нийт 7 үзүүлэлтээс бусад 69 шалгуур үзүүлэлтийн дундаж 63.1 хувь байна. Үр дүнгийн үзүүлэлтийг үнэлгээний ангиллаар нь авч үзвэл 85-аас дээш хувийн биелэлттэй 37, 60-84 хувийн биелэлттэй 7, 30-59 хувийн биелэлттэй 2, 0-29 хувийн биелэлттэй 23 үзүүлэлт байна.

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 575 зорилтын биелэлтийг үнэлгээний ангиллаар нь дүгнэж үзэхэд 242 зорилт буюу 41.7 хувь нь 85-аас дээш хувийн биелэлттэй, 118 зорилт буюу 20.3 хувь нь 60-84 хувийн биелэлттэй, 117 буюу 20.2 хувь нь 30-59 хувийн биелэлттэй, 98 буюу 16.9 хувь нь 0-29 хувийн биелэлттэй байна.

- Төлөвлөгөөнд туссан 1213 төсөл, арга хэмжээний биелэлтийн дундаж 67.9 хувь, өссөн дүнгээр 38.8 хувь байна. Үнэлгээний ангиллаар нь дүгнэж үзэхэд 659 буюу 53.4 хувь нь 85-аас дээш хувийн биелэлттэй, 147 буюу 11.9 хувь нь 60-84 хувийн биелэлттэй, 120 буюу 9.7 хувь 30-59 хувийн биелэлттэй, 287 буюу 23.3 хувь нь 0-29 хувийн биелэлттэй байна.

8.2. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хэмжихэд шаардлагатай олон улсын байгууллага болон Үндэсний статистикийн хорооноос гардаг зарим статистик тоон мэдээ, мэдээлэл, судалгааны дүн (ядуурлын түвшин, дэлхийн инновацын индекс гэх мэт) дараа оны 2-6 дугаар сард, эсхүл 2-3 жил тутам гардаг тул хуульд заасан хугацаанд бодлогын үр дүнг зорилтот түвшинд хүрсэн эсэхийг үнэлж, дүгнэх боломжгүй байдал үүсч байна. Тухайлбал,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “ ..., Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явцыг Улсын

хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор Улсын Их Хурал хэлэлцэнэ.”, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт зааснаар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө буюу 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлэхээр зохицуулсан байна.

Дээрх хугацаанд хөгжлийн бодлогын баримт бичгийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай статистик тоон мэдээ, мэдээлэл, судалгааны дүн нэгтгэгдэж гарах хугацаатай зөрүүтэй байна.

- Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлтийн явцын болон гүйцэтгэлийн тайланг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх (танилцуулах) цаглавар зөрүүтэй байна. Тухайлбал,

-Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт зааснаар урт хугацааны хөгжлийн бодлогын биелэлтийн явцын тайланг **5 жил тутам** танилцуулахаар, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэгт биелэлтийн явцын тайланг **10 жил тутам** хэлэлцүүлэхээр ялгаатай зохицуулсан байна.

-Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн **04 дүгээр сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.**” гэж заасан бол Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явцыг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн жил бүрийн **04 дүгээр сарын 01-ний дотор Улсын Их Хурал хэлэлцэнэ.**” гэж тус тус ялгаатай зохицуулсан.

8.3.Бодлого төлөвлөлтийн хүрээнд:

- Үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлогын 16 үр дүнг Алсын хараа-2050 бодлогын үр дүнтэй бүрэн уялдуулаагүй, зарим үр дүнгийн үзүүлэлт нь урт хугацааны бодлогын үр дүнтэй уялдсан хэдий ч хэмжих нэгж, хүрэх түвшинг өөр өөрөөр тодорхойлсон нь төлөвлөлт “тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх зарчим” буюу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, батлахдаа бодлогын тогтвортой байдлыг хадгалж, өмнө батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн биелэлтийн үр дүн, үнэлгээнд үндэслэх зарчимд нийцэхгүй байна.

- Мөн “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын хүрээнд хүрэх үр дүнг тодорхойлж тусгаагүй нь “төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх зарчим” буюу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлснээр бий болох үр дүнг тодорхойлж, түүнд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхой зохион байгуулалт, дэс дарааллын дагуу төлөвлөх гэсэн шаардлагыг хангаагүй байна.

- Худалдан авах ажиллагаа хийгдсэн хэдий ч гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлж, хуульд заасан гэрээ эцэслэн байгуулах хугацаанд, мөн худалдан авах ажиллагаатай холбоотой шүүхийн маргаан үргэлжилж байх хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын дагуу төсвийн хэмнэлтэд тооцож, санхүүжилтийг буцаан татсаны улмаас зарим төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Иймд дээрх хуулийн холбогдох заалтыг худалдан авах ажиллагаа зарлагдсанаас хойш гэрээ байгуулах,

шүүхийн маргаан эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд төсвийг буцаан татахгүй байхаар эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явц, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хавсралт